



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2026/2/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhur.u@audit.gov.mn">oyuntulkhur.u@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: О.Нарангарав	
	Цахим хаяг: <a href="mailto:narangerav.o@audit.gov.mn">narangerav.o@audit.gov.mn</a>	
	Аудитор: А.Дамчой	
	Цахим хаяг: <a href="mailto:damchoia@audit.gov.mn">damchoia@audit.gov.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуулаас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2025.03.25 № 1-6/346  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.ГАН-ОД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтанширээ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэг тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос он дамжин хэрэгжиж тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан 148.5 сая төгрөгийн өртөгтэй дулааны станцын зуух шинэчлэх төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "Хөрөнгө оруулалт нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна", 78 дугаар зүйлийн 78.2.4-т "Орон нутгийн өмчийн талаар Засаг дарга нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 78.2.7-д "..... нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах эрхийг хэрэгжүүлнэ", 79 дүгээр зүйл "Орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 14, 16, 17, 21 дүгээр зүйл, 211 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.4-т "Захиалагч нь барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлт гаргах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчил бүртгэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ", 5.4-т "Захиалагч

442505308

байгууллага нь барилга болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусаах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг НББ-д заавал бүртгэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэл хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

<i>(мянган төгрөгөөр)</i>			
№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	577,615.15	478,754.47
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	285,106.04	129,123.47
3	АВЛАГА	128,517.08	198,759.38
4	БАРАА МАТЕРИАЛ	163,992.03	150,871.61
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,068,320.67	3,350,262.16
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,068,320.67	3,350,262.16
7	Биет хөрөнгө	2,806,573.54	3,089,003.16
8	Биет бус хөрөнгө	261,747.13	261,259
<b>9</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>3,645,935.82</b>	<b>3,829,016.63</b>
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР	525.57	10,958.72
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	525.57	10,958.72
12	Өглөг	525.57	10,958.72
<b>13</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,645,410.25</b>	<b>3,818,057.91</b>
14	Засгийн газрын хувь оролцоо	3,645,410.25	3,818,057.91
15	Засгийн газрын оруулсан капитал	1,115,260.87	1,105,559.52
16	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	9,701.36
17	Хуримтлагдсан үр дүн	1,861,982.36	2,034,630.02
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	668,167.02	668,167.02
<b>19</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>3,645,935.82</b>	<b>3,829,016.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,889,691.66</b>	<b>2,942,112.38</b>
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,534,341.61	1,350,827.37
3	Орлогын албан татвар	577,293.75	542,815.00
4	Хувь хүний орлогын албан татвар	577,293.75	542,815.00
5	Хөрөнгийн албан татвар	25,129.02	11,352.97
6	Бусад татвар, төлбөр, хураамж	931,918.84	796,659.40
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,377,344.45	1,591,285.01
8	Нийтлэг татварын бус орлого	-	667,996.20
9	Тусламжийн орлого	-	407,826.21
10	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	515,462.60
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,978,005.60	-
<b>12</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,691,195.75</b>	<b>2,712,318.69</b>
13	УРСГАЛ ЗАРДАЛ	4,691,195.75	2,712,318.69
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,373,353.44	1,884,596.75
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	868,149.55	968,161.94
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,361.94	122,360.12
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	295,002.33	306,966.65
18	Хангамж, бараа материалын зардал	75,090.72	102,229.63
19	Нормативт зардал	3,920.00	-
20	Эд хогшил, урсгал засварын зардал	34,694.52	28,458.33
21	Томиллолт, зочны зардал	15,440.00	11,510.00
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	679,407.74	30,973.19
23	Бараа үйлчилгээний бусад зардал	293,286.64	313,936.88
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,317,842.31	827,721.94
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,198,495.91	229,793.69
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	624,648.63	57,146.03
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(624,648.63)	(57,146.03)
<b>28</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>573,847.28</b>	<b>172,647.66</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,071,562.97	3,071,562.97
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,071,562.97	3,071,562.97
3	Тайлант үеийн үр дүн	573,847.28	573,847.28
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,645,410.25	3,645,410.25
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,645,410.25	3,645,410.25
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,645,410.25	3,645,410.25
7	Тайлант үеийн үр дүн	172,647.66	172,647.66
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,818,057.91	3,818,057.91

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,584,563.82</b>	<b>2,337,960.65</b>
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,534,341.61	1,350,827.37
3	Орлогын албан татвар	577,293.75	542,815.00
4	Хөрөнгийн албан татвар	25,129.02	11,352.97
5	Бусад татвар, төлбөр, хураамж	931,918.84	796,659.40
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	42,148.50	121,703.51
7	Газрын төлбөр	472,170.33	466,155.89
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	417,600.00	208,800.00
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,953.35	987,133.28
10	Нийтлэг татварын бус орлого	56,953.35	55,781.75
11	Тусламжийн орлого	-	415,888.93
12	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	515,462.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,993,268.86	-
<b>14</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,534,855.05</b>	<b>2,491,943.22</b>
15	УРСГАЛ ЗАРДАЛ	4,534,855.05	2,491,943.22
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,208,559.02	1,671,776.31
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	876,019.55	976,684.85
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,190.62	122,585.69
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	295,002.33	306,966.65
20	Хангамж, бараа материалын зардал	57,009.39	30,079.42
21	Нормативт зардал	6,606.00	-
22	Эд хогшил, урсгал засварын зардал	35,894.80	46,017.33

23	Томилолт, зочны зардал	15,440.00	11,550.00
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,084.20	167,336.54
25	Бараа үйлчилгээний бусад зардал	10,312.13	10,555.82
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,326,296.03	820,166.91
<b>27</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>49,708.77</b>	<b>-153,982.57</b>
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	30,149.80	2,000.00
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,149.80	2,000.00
30	Дотоод эх үүсвэрээр	30,149.80	2,000.00
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(30,149.80)	(2,000)
<b>32</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>19,558.97</b>	<b>(155,982.57)</b>
33	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	265,547.07	285,106.04
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	285,106.04	129,123.47

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,665,212.10</b>	<b>2,270,149.67</b>	395,062.43	85.18
11	Татварын орлого	1,281,756.60	1,350,827.37	(69,070.77)	105.39
110	Орлогын албан татвар	512,459.80	542,815.00	(30,355.20)	105.92
1100	Хувь хүний орлогын албан татвар	512,459.80	542,815.00	(30,355.20)	105.92
113	Хөрөнгийн албан татвар	9,390.00	11,352.97	(1,962.97)	120.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	759,906.80	796,659.40	(36,752.60)	104.84
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,000.00	121,703.51	(113,703.51)	1,521.29
1181	Газрын төлбөр	601,906.80	466,155.89	135,750.91	77.45
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	150,000.00	208,800.00	(58,800.00)	139.20
12	Татварын бус орлого	1,383,455.50	919,322.30	464,133.20	66.45
120	Нийтлэг татварын бус орлого	303,836.50	47,419.38	256,417.12	15.61
120003	Торгуулийн орлого	3,000.00	5,281.00	(2,281.00)	176.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	26,946.20	33,194.88	(6,248.68)	123.19
1200042	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	264,390.30	-	264,390.30	-
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	9,500.00	8,943.50	556.50	94.14
122	Тусламжийн орлого	1,079,619.00	871,902.92	207,716.08	80.76
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	515,462.60	515,462.60	-	100.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,665,212.10</b>	<b>2,434,337.16</b>	230,874.94	91.34

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,665,212.10	2,434,337.16	230,874.94	91.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,814,485.90	1,639,740.35	174,745.55	90.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	993,133.50	976,684.85	16,448.65	98.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,391.70	122,585.69	2,806.01	97.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	367,690.30	306,966.65	60,723.65	83.49
2104	Хангамж, бараа материалын зардал	44,883.00	26,590.13	18,292.87	59.24
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,260.00	48,017.33	2,242.67	95.54
2107	Томилолт, зочны зардал	13,524.00	11,550.00	1,974.00	85.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,328.40	145,557.60	69,770.80	67.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,275.00	1,788.10	2,486.90	41.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	850,726.20	794,596.81	56,129.39	93.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	839,276.20	793,596.87	45,679.33	94.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,450.00	999.94	10,450.06	8.73
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,106,418.20	(164,187.49)	1,270,605.69	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,106,418.20)	164,187.49	(1,270,605.69)	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,106,418.20)	164,187.49	(1,270,605.69)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	264,390.33		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	100,202.84		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	-	<b>35,384.51</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	35,384.51
122	Тусламжийн орлого	-	35,384.51
1221	Хандив тусламж /дотоод/	-	35,384.51
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	35,384.51
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	21,500.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,884.51
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>25,768.24</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	25,768.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	25,768.24
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,489.29
210402	Тээвэр, шатахуун	-	3,489.29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	21,778.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	21,778.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	500.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	<b>9,616.28</b>
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(9,616.28)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(9,616.28)

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>8,362.40</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,362.40
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,362.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,362.40
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,596.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,596.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,596.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,596.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,596.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	-	<b>(1,596.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-	<b>6,766.40</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,448.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,448.00	19,214.40

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллагын 2, тусгай сангийн 2, нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 төсвийн байгууллагад дүгнэлт гаргаж, тусгай сангийн 2 тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийх аудит хийсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын 1 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,060.7 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 1,060.7 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 148.6 сая төгрөгийн 5 зөрчилд 148.6 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудит болон Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулаагүй алдаа, зөрчил 148.6 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлаас 112.1 сая төгрөгөөр хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 225.2 сая төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад 225.2 сая төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын төлөвлөгөөг аймаг, сумын ИТХ-ын тогтоолтой тулгахад 225.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	0.2	1	0.2	-	-	1	0.2	-	-	-	-
Засаг даргын тамгын газар	4	182.8	2	178.4	2	4.4	4	182.8	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	2	29.7	-	-	2	29.7	2	29.7	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сан	2	848.0	1	839.3	1	8.7	2	848.0	-	-	-	-
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	225.2	-	-	1	225.2	1	225.2	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>1,285.9</b>	<b>4</b>	<b>1,017.9</b>	<b>6</b>	<b>268.0</b>	<b>10</b>	<b>1,285.9</b>	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Засаг даргын тамгын газар	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Орон нутгийн хөгжлийн сан	3	148.6	-	-	3	148.6	-	-	-	-	-	-	-
Төсвийн төвлөрүүлэн захирагч	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>148.6</b>	-	-	<b>4</b>	<b>148.6</b>	<b>1</b>	-	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-